

XX ЗУУНЫ ЭХЭН ҮЕИЙН МОНГОЛ ОРНЫ ТАЛААРХ БРИТАНИЙ АЯЛАГЧДЫН ХОЁР ТЭМДЭГЛЭЛИЙН ТУХАЙД ЦУХАС

*Д.Золбоо**

Аль ч улс үндэстний түүхийг бичих, тодруулахад тухайн улс орноор жуулчлан өнгөрсөн хүмүүсийн аян замын тэмдэглэл чухал байр суурь эзэлдэг. Төв Азийн нүүдэлчин овог аймгийнхны түүхийг хөрш зэргэлдээ суурин соёл иргэншилтэй хятад, арабын аялагчдын тодорхой хэмжээнд бичиж үлдээсэн бол өрнийн улс гүрнүүдэд монголчуудыг таниулахад Их Монгол Улсын үед аялан ирж байсан Марко Поло, В.Рубрук, бүр хожим XVIII зуунаас удаа дараа ирж байсан Оросын шинжилгээний багынхан ихээхэн хувь нэмэр оруулсан.

XX зууныг хүртэлх Монгол, Британий харилцаанд холбогдох хугацаанд хоёр орны харилцааны холбогдолтой аян замын тэмдэглэл, архивын албан ёсны баримт бичиг одоогоор мэдэгдээгүй байгаа ч энэ нь тийм баримт бичиг, эх сурвалж байхгүй гэсэн үг биш юм.

Харин Монгол орноор аялан өнгөрсөн гадны аялагчдын талаар тэмдэглэж үлдээсэн баримт Үндэсний төв архивт цөөнгүй хадгалагдаж байна. Тухайлбал, Цэцэн хан аймгийн чуулган даргын хөмрөгийн баримт бичигт хадгалагдаж буй Хэвт ёсны тэргүүн онд /1909/ бүртгэсэн “Орос хар лам, олон Орос, Инь (Британи), Фа (Франц) улс худалдаалах дүрэм хэмжээ зэргийн тухай дэвтэр” гэдэг нэгэн данс байна.¹ Энэхүү дансанд Хүрээний манж сайдын газраас Түшээт хан аймгийн чуулган даргын газарт явуулсан Тэнгэрийн тэтгэснээс Бадруулт төрийн сүүлчийн онууд хүртэлх хугацаанд гадаадын иргэлтэй холбогдсон чухал баримтыг оны дарааллаар бүртгэсэн байна. Түүнд Англи, Францын худалдаачид, зорчин явагчид, тэдний бараа тээшийг тээн явах тухай шууд болон дам холбогдох цөөнгүй баримт бүртгэсэн байдаг. Энэ мэтчилэн түүхэн баримт Үндэсний төв архив, Гадаад хэргийн төв архивын сан хөмрөгт мэр сэр бий.

Худалдаа аж ахуйн үйл ажиллагаанаас гадна шашин номын ухуулгын ажлаар Британий зарим нэгэн хүн манайд ирж суурин амьдарч байсан бөгөөд энэ талаар 1910 оны эхээр Монголд ирсэн английн иргэн Жон Хэдлэй гэдэг хүний бичсэн “Харанхуй балай Монгол орноор жуулчилсан нь” гэдэг ном бичсэн байдаг.² Энэ номыг өмнө нь манай түүх судлаачид тодорхой хэмжээнд ашиглан судлаж, судалгаандаа эш татсаар иржээ.

Улам бүр даяаршин буй өнөөгийн нийгэм техник технологийн хөгжлийн үрээр бид түүхэн ховор, архивын баримт бичгүүдийн хүссэн

* Д.Золбоо - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

газраасаа цахим хэлбэрээр танилцан, уншиж судлах өргөн боломж нээгдсээр байна. Тухайлбал, Британий үндэсний архивын цахим санд байрлуулсан баримтаас Монголын түүхэнд холбогдох анхны баримт нь Британий Гадаад хэргийн яамны Улс төрийн тагнуулын хэлтсээс 1919 оны 4 дүгээр сарын 15-нд бэлтгэсэн “Орос, Хятадын хоорондын харилцааны гол үйл явдлын талаарх меморандум”, 1920 оны 1 дүгээр сарын 12-ны “Гадаад Монгол ба 1919 оны Хятадын цэргийн үйл ажиллагааны талаарх меморандум” зэрэг баримт бичигт Монгол болон бүс нутгийн талаарх нэлээд дэлгэрэнгүй илтгэл болгон гаргасан байна.

Энэ удаад Монголын тэр тусмаа, XX зууны эхэн үеийн түүхийн судалгааны эргэлтэд тэр бүр ороогүй хоёр тэмдэглэлийн талаар товч сонирхуулж байна. Эхнийх нь Британиас Хятадад сууж байсан консул С. W. Campbell –ийн бичсэн “Монгол дахь аялал, 1902”³ хэмээх ном юм. Бидний олж үзсэн 2000 онд хэвлэгдсэн уг хэвлэлд аяллын явцад бэлтгэн Лондонд ирэхдээ илтгэлдээ оруулсан зургаан ширхэг газрын зургийг хавсаргажээ. Тэрээр 1902 оны 6 дугаар сард Бээжин хотоос аяллаа эхлэн Их цагаан хэрэм, Говийг туулан Монгол орны зүүнээс баруун тийш Өргөө, Эрдэнэ зуу хийд хүртэл 4 сарын турш аялсан байна. Энэхүү тэмдэглэл нь, Бээжингээс Хаалган хүртэл, Хаалган, Цахар хошуу, Халхын хант улс, Өргөө, Хэнтийн уулс, Орхоны хөндий ба Эрдэнэ зуу (Хархорин), Хархориноос Лондон, Хүн ард, амьдрал ахуй, худалдаа, бараа бүтээгдэхүүний талаарх ажиглалт, Умард болон Зүүн Монголд хийсэн Оросын судалгаа шинжилгээ, аяллын түүхэн үйл явдлын товчлол гэсэн хэсгүүдээс бүрдэх 155 тал хуудастай. Мэргэжлийн дипломат хүний нүдээр нарийн ажиглан бичсэн энэхүү тэмдэглэл нь тухайн үеийн Монгол орон, Өвөр Монголын талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг өнөөгийн бидэнд өгч чадах юм. Тэрээр “...би өөрийн нүдээр хүн амын тооны албан ёсны баримт олж хараагүй боловч Өвөр болон ар Монгол дахь монголчуудын тоо 5 сая орчим болох хэдий ч олж авсан бүх мэдээллийн дагуу цөөрч байгаа ард түмэн гэж хэлж болно. ...Хэрвээ бид өнөөгийн Монголчуудын амьдралын хэв маягийг Чингис хааныг тэнгэрт хальснаас 30 жилийн дараа Монгол оронд ирж байсан Рубрукийн тэмдэглэж үлдээсэнтэй харьцуулан гүйлгэн харвал онцын ялгаагүй болох нь харагдана. Өнөөгийн дундаж монголчуудын идэж, ууж, өмсч зууж байгаа нь өөрсдийнх нь өвөг дээдсийн үеийн хэрэглэж байснаас огтын ялгаагүй. Хэрвээ 1200-гаад оны үеийн Монгол хүнийг өнөөдрийн тэдний амьдралд авчирвал, тэрээр эсгий гэр, гэрийн эд хогшил зэргийг хэрэглэхэд төвөггүй байх бөгөөд хамгийн их тайлбарлаж зааж сургах зүйл нь айл болгоны хойморт байх Бурхан хэмээх Буддын шашны жижигхэн баримал зэрэг зүйл байх биз” хэмээн тэмдэглэн үлдээжээ. Мөн аяллын турш хэрэглэсэн уналгын талаар бичихдээ “Би 6 дугаар сарын 3-наас 8

дугаар сарын 30-ны хооронд Бээжингээс Хэрлэн хүртэл 1300 мил (ойролцоогоор 2000 гаруй км Д.З) аялахдаа зургаан настай нэгэн монгол морь унаж явсан бөгөөд (пони “pony” гэж буулгажээ. Д.З) хэцүү бэрх олон газраар явж, зарим тохиолдолд нүхэнд хөлөө бэртээх зэрэг бэрхшээл тулгарч байсан хэдий ч нэг ч удаа өвчин тусч, ядарч туйлдаагүй. Түүнийг орхих уед хэдийгээр бага зэрэг тамирдаж, турсан боловч цовоо цолгин хэвээрээ, намайг хаана ч хүргэж өгөх чадалтай мэт харагдаж байлаа”, “...Аялалын турш хэрэглэсэн нэг тэмээ ойролцоогоор 300 lbs (ойролцоогоор 140 кг Д.З) ачааг Хараа усаас Өргөө хүртэл 1270 мил (ойролцоогоор 2000 км Д.З) газар 62 өдрийн турш жин тээвэрлээд аяллын төгсгөлдөө очиход тамир тэнхэнд нь онцын өөрчлөлт ороогүй байсан. Үнэндээ миний аялал тэмээн жингээр хийхэд тийм ч их тохиромжтой бус байсныг тэмдэглэх хэрэгтэй. Энэ нь монгол тэмээн жин нь өдрийн халуунд явахад бэрхшээлтэй, тэмээг шөнийн цагаар идээшлүүлдэггүйгээс шалтгаалан ихэнхдээ шөнө оройн цагаар аялах шаардлагатай байхад миний хувьд аялан яваа газар орноо сонирхон судлах зорилгын үүднээс ихэндээ өдрийн цагаар аялах болдогтой холбоотой” гэх зэргээр монгол ахуйн талаар сохирхолтойгоор тэмдэглэн үлдээжээ. Тэрээр Монгол орны тухайн үеийн нийгэм эдийн засгийн талаар “Дээд Хэрлэнд байрлах худалдааны пуусийн байранд нэлээд хэд хоног өнгөрөөсний хувьд Монгол оронд хийгддэг худалдаа, наймааны ерөнхий зургийг хамгийн сайн тодорхойлолтыг гаргаж чадахаар болсон. Миний байрласан Lin Sheng Yuan пуусийн байшин нь Өргөөд анх Маймаачин байгуулагдсан 200 гаруй жилийн тэртээгээс суурьшсан байна. Тэдний хийдэг гол үйл ажиллагаа нь бартер буюу бараа солилцооны худалдаагаар (зэс сав суулга, Оросын арьсан гутал, малгай, өрөм, даавуу, сатин, хатгамал, торго, ноосон сүлжмэл, Япон нудний шил, хөөрөг, ташуулын хулс, хятад дөрөө, хазаар, эмээл, тамхины даалин, хэт цахиур, ган төмөр, гаанс, хуж, япон шүдэнз, гоёлын цэцэг, сэвүүр, нум сум, овъёос болон буудайн гурил, хуурсан шар будаа, хатаасан чавга, орос цагаан чихэр, мөсөн чихэр, хятад архи болон цай) зэргийг адуу мал, эсгий, арьс шир, бугын эврээр сольдог байна. Энэ пуусийн Туул, Хараа, Дээд Хэрлэн дэх салбарт хазгай мурий монгол хэлтэй Шанси мужаас ирсэн 30 гаруй хүн ажиллана. Эдгээр хүмүүсийн нэг нь ч Монголд суурин амьдардаггүй бөгөөд жилд нэг удаа ээлж дараалан Шанси явахдаа цуглуулсан түүхий эдээ ачаалан Говийг туулан Хаалган хот дахь өөрийн пуусийн байранд аваачин Хойд Хятадын томоохон хотууд дахь бөөний худалдааны пуусуудад худалддаг байна. ... Миний нэгэн орос найз хятад худалдаачид хэрхэн монголчуудыг мөлждөг аргыг тайлбарлаж өгсөн юм. Хувцас хунар, гоёл чимэглэлд хандах нүүдэлчдийн зан яг хуухэд шиг, юу харна түүнийгээ авахыг хүсдэг

байна. Энэхүү дутагдлыг нь хятад худалдаачид ашигладаг... Хятад худалдаачидын ашиг хаана ч байхгүй өндөр, Долон нуурт зарагдаж байгаа гурилын үнэ Халхын голд нугарч зарагддаг бол, шар будаа гурав дахин үнэтэй болдог” гэх зэргээр гэнэн томоогүй зангаасаа болж жирийн ард иргэдээс эхлэн засаг ноёд хэрхэн өр ширэнд баригддаг талаар жишээ татан тэмдэглэсэн байна. Мөн тэрээр Өргөө дэх Орос, Хятадын хамтарсан банкны үйлчилгээ зэрэг зарим нэгэн сонирхолтой зүйлсийн талаар тэмдэглэн үлдээжээ.

Удаах нь Beatrix Bulstrode хэмээх англи хатагтайн 1920 онд Лондонд хэвлэгдсэн “Монголд хийсэн аялал”⁴ нэртэй ном юм. Өмнөх номноосоо ялгагдах гол онцлог нь энэхүү бүтээлд зохиогчийн авсан 50 гаруй гэрэл зургийг багтаасан явдал юм. Тэмдэглэн үлдээсэн чухал сонирхолтой бичвэрээс гадна тэдгээр гэрэл зураг нь тухайн үеийн Монгол орон, монголчуудын талаар юугаар ч сольшгүй үнэтэй мэдээллийг бидэнд өгч чадах юм. Тухайд үед Бээжин хотноо “Times” сэтгүүлийн сурвалжлагчаар ажиллаж байсан ноён David Fraser-ийн номын анхны хэвлэлийн өмнөх үгэндээ дайн тулааны нөхцөл байдалд байгаа Монгол оронд хийсэн аюул, эрсдэлтэй аяллын үр дүнг өндрөөр үнэлсэн байдаг. Эмэгтэй хүний гярхай нүдээр харж үзсэнээ нэг бүрчлэн дэлгэрэнгүй буулгасан нь ХХ зууны эхэн үеийн монголчуудын амьдралыг нүдний өмнө зурах мэт тодорхой гаргаж өгчээ. Тэрээр Монголд ирэхдээ Өвөр Монголоос говийг шууд гатлалгүй, зүүнтэйгүүр Харбин, Чита орчмоор Оросод нэвтрэн Дээд үд, Хиагтаар дамжин Өргөөд хүрэлцэн иржээ. Тэрээр Нийслэл хүрээнд ирсэн анхны сэтгэгдлээ “Туул голын хойд эрэгт байрлах Өргөө нь Хятадын захын хот Хаалганаас 600 мил, Оросын өмнөд хилийн Хиагтаас 200 милийн зайд оршино. Урт үргэлжлэх эмх замбараагүй эрээн мяраан сум хийд, хэсэг хэсгээр буусан гэр, өндөр шургааган хашаатай модон байшин, тод өнгөөр будсан олон тооны саравч шиг харагдах Төвд маягийн мөргөлийн хурд, хуухдийн тоглоом шиг харагдах цөөн тооны суудрэвчтэй зуны байшин, хятад загварын бөөгнөрөлдсөн байшин зэрэг нь Монгол улсын нийслэлд ирсэн бидний анхны сэтгэгдэл юм. Хотын баруун хэсэгт орших Ариун хотод 30 мянга хүртэл лам нар суух бөгөөд нар жаргаснаас хойш жирийн хүмүүс явахыг хориглодог байна. Маймаачин хэмээх хятад хот нь хотын зуун хэсэгт орших бөгөөд энэ хоёр хэсгийг Оросын консул, орос худалдаачдыг хамгаалах цэргүүдийн байрлах байр болон эмх замбараагүй барьсан жижиг байшингууд холбох ажээ. Богд уул нь ан амьтан элбэгтэй боловч ан хийх, Туул голын өмнөд эргээр гэр барих нь хориотой. Уламжлалаа сахилгүй Богд уулаас шувуу, ан амьтан агнан, загас барьвал цаазаар авах буоу насаар нь хорих ял шийтгэх бөгөөд хууль ёс сахиугүй нүгэл


үйлдсэн гадны хүмүүсийг ч мөн адил яллах хуультай” хэмээн тэмдэглэсэн байна. Тэрээр цааш нь “Бидний аялалын үеэд Өргөө болон ер нь нийт Монгол даяар Оросуудыг эс тооцвол Европын улсын хоёрхон хүн байсан бөгөөд Их Британи, Ирландаас байгаа цорын ганц төлөөлөл нь ноён Gull болон миний бие байв. Тэр хоёр нь Норвеги, Германы иргэд бөгөөд Монголд худалдааны ажил эрхэлдэг ажээ” гэсэн байна. Тэрээр Нийслэл хүрээнд байх хугацаандаа эрийн гурван наадам, цамын бүжиг зэргийг үзэж сонирхон олон сонирхолтой гэрэл зураг авсан байх бөгөөд, Жанрайсиг, Богдын ордон болон морь тэмээний зах зэрэг олон газраар зорчсоноо тэмдэглэн үлдээжээ.

Энэхүү богинохон танилцуулгад дэлгэрэнгүй танилцуулах боломж мөхөс байгаа тул Британий аялагчдын аян замын эдгээр тэмдэглэлийг монгол хэлнээ хөрвүүлэн уншигчдын хүртээл болгон судалгааны эргэлтэд оруулах нь XX зууны Монголын түүх судлалын үйлсэд ихээхэн хувь нэмэр оруулах нь дамжиггүй.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. YTA x-M-31 д-1 хн-2164
2. Tramps in dark Mongolia / by John Hedley. London T. Fisher Unwin 1910.
3. Travels in Mongolia 1902. A Journey by C.W.Campbell The British Council in China, London The Stationary Office
4. A Tour in Mongolia, by Beatrix Bulstrode, London 1920

A TOUR IN MONGOLIA





BOGDO'S BODYGUARD